

НИЙСЛЭЛИЙН БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗАР  
МОНГОЛЫН ЖЮУ ЖИЦҮГИЙН ХОЛБОО

ТАЙЛАН

2023 оны 07 дугаар сарын 24

Улаанбаатар хот

ЖЮУ-ЖИЦҮГИЙН ДЭЛХИЙН АВАРГА  
ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭН

Нийслэлийн Засаг даргын 2023 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн А/675 дугаар захирамжийн дагуу Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотод 07 дугаар сарын 14-20-ны өдрүүдэд Жюү жицүгийн насанд хүрэгчдийн 20 дахь удаагийн Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулсан.

Нийслэлийн Засаг даргын захирамжийн дагуу тэмцээнийг зохион байгуулах Нийслэлийн Засаг даргын нийгмийн салбар, ногоон хөгжил болон агаар, орчны бохирдлын асуудал хариуцсан орлогчоор ахлуулсан 23 гишүүдтэй ажлын хэсгийн хурлыг 2023 оны 06 дугаар сарын 20-ны өдөр зохион байгуулсан.



Монголын Жюү жицүгийн холбооноос 2023 оны 06 дугаар сарын 06-ны өдөр "Милланиум Плаза"-д хэвлэлийн бага хурлыг зохион байгуулсан.

Тус арга хэмжээний үеэр Монголын Жюү жицүгийн холбооны удирдах зөвлөл, дэд ерөнхийлөгчөө танилцуулснаас ДАШТ-д хамтарч ажиллах "Мөнгөн", "Хүрэл" түнш компани, байгууллагуудтай албан ёсоор хамтарч ажиллах гэрээнд гарын үсэг зурсан юм.



ОУЖЖХ-ноос 2022 оны дөрөвдүгээр сард 20 дахь удаагийн Жюү жицүгийн ДАШТ-ийг манай оронд зохион байгуулах эрхийг өгсөн.



Жюү жицүгийн насанд хүрэгчдийн 20 дахь удаагийн Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнийг АНДЛАЛ, ХҮНДЛЭЛ, ХӨГЖИЛ" уриатай Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд 60 гаруй орны 1000 орчим шилдэг тамирчин насанд хүрэгчдээс гадна мастерс, пара ангилалд өрсөлдсөн.

МОНГОЛЫН ЖЮҮ ЖИЦҮГИЙН ХОЛБОО